

Иргэдийг дээрэмдэж “болно”

***/асуудал дэвшүүлсэн сурвалжилга/***

Төр нь иргэдийнхээ бизнесийг “булаадаг” хачирхалтай жишиг ардчилсан монгол улсад байна. Төр улам данхайн томорч, хувийн хэвшил нь улам агшин жижгэрсээр.

Монгол улс 91 сая малтай. Жилд 23 сая нэхий боловсруулах нөөцтэйгөөс ердөө найман саяыг боловсруулж, үлдсэн нь хаягддаг. Монголчууд малаас хаях юм байхгүй гэдэг ч нэхийгээ боловсруулж чадахгүйгээс хятадуудад хямд үнээр “бэлэглэдэг” болоод удаж байна. Уг нь малын ашиг шимийг монголчуудад нь үлдээх, жилд 10-15 сая нэхий боловсруулах хүчин чадалтай аж үйлдвэрийн парк байгуулах ажил эхэлсэн ч төрийн бодлогогүй шийдвэрийн балгаар зогсчээ. Тодруулбал, “дархан арьс ширний цогцолбор”-ын бүтээн байгуулалтыг хоёр ч засгийн газар дэмжиж, хамтран ажиллахаа амласан. Төрдөө итгэсэн хувийн хэвшлийнхэн 10 сая гаруй ам.долларын санхүүжилт өөрсдөөсөө гарган, үйлдвэр барьж эхлэв. Харин төр нэг л өдөр нүүрээ буруулж, үүнтэй яг ижил зориулалттай төслийг яг ижил байршилд амдан эхлүүлжээ. Төрдөө дээрэлхүүлсэн хувийн хэвшлийнхэн модоо барьж, цалингаа тавьж чадахгүйгээс ихээхэн хэмжээний өрөнд унасан үйл явдал яг одоо өрнөж байна.

**Жилд 242 сая ам.долларын ашиг замхрав**

Монгол улсын ерөнхийлөгч асан х.баттулгын санаачилгаар дархан-уул аймгийн хонгор сумд 2019 оноос “дархан арьс ширний цогцолбор”-ыг анх барьж эхэлсэн. Гүйцэтгэгчээр “дархан арьс ширний цогцолбор” ххк ажиллаж байгаа юм. Цогцолборыг байгуулахад нийт 225 сая ам.доллар шаардлагатай. Харин ашиглалтад орсны дараа

цогцолборын нийт хүчин чадлын 60 хувийг л ашиглахад, жил бүр 242 сая ам.долларын ашигтай ажиллах тооцоо гарсан. Төсөл хэрэгжсэнээр малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах, дэлхийн стандартад нийцсэн, нэмүү өртөг бүхий арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд нийлүүлнэ. Мөн 2500 шууд ажлын байр, 7500 шууд бус ажлын байр бий болно гэж тооцоолжээ. Төслийн ерөнхий төлөвлөгөөг испани улсын “ипап инженеринг” компани хийж, зураг төслүүд гарсан. Төслийн талбай 180 га-г хамарсан бөгөөд 60 га талбайд ноос боловсруулах үйлдвэр, бохир ус цэвэрлэх байгууламж хийхээр төлөвлөжээ. Мөн цахилгаан түгээх, хангах дэд станц, инженерийн шугам сүлжээ, уурын станцын дэд бүтцийн ажлуудыг ч хийх юм. Үр дүнд нь дархан хотын орхигдоод байсан үйлдвэрийн объектууд сэргэж, аж үйлдвэрийн бүс өргөжин тэлэх боломжтой аж.

Дээрх боломжийг олж харсан “дархан арьс ширний цогцолбор” компани хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, мал эмнэлгийн ерөнхий газар зэрэг төрийн байгууллагатай бодлогын гэрээ байгуулж, хөгжлийн банкнаас зээл авснаар энэхүү төр, хувийн хэвшил хоорондын “адал явдал” эхэлсэн байна. Тухайн үед ерөнхийлөгч байсан х.баттулга хэд хэдэн удаа тус цогцолборын ажилтай танилцаж, хурдан шуурхай ашиглалтад оруулахыг ч үүрэгдэж байв. Тухайлбал, уих-ын чуулганы үеэр “нөхөгддөг баялаг болох мал аж ахуйн орлогыг эрс нэмэгдүүлэхэд арьс шир, малын түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг түлхүү дэмжих нэн шаардлагатай байна. 30 жил ярьсны эцэст эхэлсэн, дарханд босгож байгаа арьс шир, ноос ноолуур боловсруулах, бүтээгдэхүүний хөнгөн үйлдвэрлэлийн паркийг та бүхэн бодлогоор дэмжиж, хурдан шуурхай ажиллаасай гэж хүсэж байна. Арьс шир боловсруулах 13 үйлдвэр, жилд 10 мянган тонн ноос боловсруулах, ноос ноолуур угааж самнах үйлдвэр,

түүнийг цэвэрлэх байгууламж, дэд бүтцийн барилга байгууламж баригдаж байгаа. Үүнийг яаралтай үргэлжлүүлж, түргэн ашиглалтад оруулах хэрэгтэй байна. Та бүхэн иргэдийнхээ өмнүүр орж, өөрсдөө боломж эрэлхийлэлгүй шийднэ гэж найдаж байна” хэмээж байв.

### **Хэлсэн үгнийх нь шүлс, гаргасан тогтоолынх нь бэх хатаж амжаагүй байхад...**

“дархан арьс ширний цогцолбор” ххк өнөөдрийг хүртэлх хугацаанд цогцолбор байгуулах төсөлд 54 тэрбум төгрөг зарцуулжээ. Үүний 18 тэрбум төгрөгийг хөгжлийн банкнаас бонд авч санхүүжүүлсэн. Бүтээн байгуулалтын 60 хувийг гүйцэтгэсэн ч, санхүүжилтгүйн улмаас цааш үргэлжлүүлэх боломжгүй болж, жил гаруйн хугацаанд зогсонги байдалд оржээ. Үүний гол шалтгаан нь хэлсэн үгнийх нь шүлс, гаргасан тогтоолынх нь бэх хатаж амжаагүй байхад төр өөрийн эзэмшлийн арьс ширний цогцолбор байгуулах төсөл эхлүүлсэн байна. Тодруулбал, ххаахүя дээр дурдсан хувийн хэвшлийнхний цогцолбор барьж буй талбайн хажууханд, яг ижил цогцолбор барьж эхлэх нь тэр. Төсвөөс 50 тэрбум төгрөг гаргаж, 25 га талбайд шинэ тэзү болон бусад зардлын тендер зарлаад амжжээ. Энэ талаар тодруулахаар бид дархан хотыг зорьсон юм.

Төрийнхөнд санаагаа, ажлаа булаалгасан “дархан арьс ширний цогцолбор” ххк-ийн гүйцэтгэх захирал д.энхбаяраас энэ талаар тодруулахад “дархан арьс ширний цогцолбор нь төр болон хувийн хэвшил, хөгжлийн банкны дэмжлэгтэй. Өнөөдөр бидэнд тулгарч буй гол асуудал нь төр нэг гараараа хийсэн зүйлээ нөгөө гараараа нурааж байгаа явдал. Яг л монголчууд тамын тойрогт нэг нэгийгээ татаж

унагадаг гэдгийн бодит жишээ болж байна. Учир нь бидний нийт санхүүжилтийн гуравны нэгийг хийсэн хөгжлийн банкны санхүүжилтийг тэд муутгаж байна. Яаж гэвэл, 25 га-д тусдаа тавхан үйлдвэрийг аж үйлдвэрийн парк болгоно гэж. Дэлхийд онигоонд орох хэмжээний жижиг зүйлийг парк гэж хэлж, засгийн газрын 185/234 тоот тогтоолыг зөрчиж байна. Нөгөө талаас төр засагтаа итгэж, энэ бүх бүтээн байгуулалтыг хийсэн хөрөнгийг царцаалаа. Олон улсад аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийг улс нь хийж байж, дараа нь гаднын хөрөнгө оруулалтыг татдаг. Гэтэл бүх эрх зүйн хувьд засгийн газар, уих-ын түвшинд бодлого нь таатай болж эхэлмэгц биднийг асар хүнд байдалд оруулж байна. Одоо төр, хувийн хэвшил хамтарсан гэрээ хийчих л юм бол гаднын хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулахад бэлэн гэдгээ илэрхийлж байгаа” гэх тайлбарыг өгсөн юм.

үүсээд буй нөхцөл байдлын талаар орон нутгийн захиргаанаас тодруулах гэтэл “дархан-уул аймгийн засаг дарга амралтаа авсан, орлогч одоогоор ажилдаа ирээгүй байна” гэх шалтгаанаар хоёр ч удаа хоосон буцав. Харин дархан-уул аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга п.батсүх “орон нутаг, хувийн хэвшилтэй хамтарсан нэг ажил хийж байна. Улсын төсвөөр бас нэг хийгдэж байна. Дараагийн төсөл ямар шугамаар хийхийг бид мэдэхгүй, энэ бол засгийн газраас хийж байгаа ажил” гэж тайлбарлав. Эх сурвалжийг тэнцвэртэй байлгах үүднээс ххаахүя-ны хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга м.дондогдоржтой холбогдоход “хуралтай байна, дараа больё” хэмээсэн ч, товлосон өдрөө эрүүл мэндийн асуудалтай байна гэх шалтгаанаар хариу өгөхөөс дахин татгалзсан юм. Биднийг уг асуудлыг сурвалжилсны дараахан “дархан арьс ширний

цогцолбор” ххк-ийн гүйцэтгэх захирал б.энхбаярыг тодорхой бус шалтгаанаар цагдан хорьжээ.

### **Төрдөө хууртсан тэд юу өгүүлэв?**

Төр хэлсэн, тохирсноосоо буцаа л биз гэх хүн гарч магад. Гэвч энэ “адал явдал” бизнесийн эрсдэл нь амин зуулгаар нь хэмжигддэг хувийн хэвшлийнхэнд хүндээр тусаж байна. Дээрх цогцолборыг төртэй хамтарч хийнэ гэж хөрөнгөө зарцуулсан хувийн хэвшлийнхэн цалингаа тавьж чадахгүйд хүрчээ. Царцаад буй төсөлд зарцуулахаар хөгжлийн банкнаас зээлсэн зээлийн хүү өдрөөс өдөрт нэмэгдсээр, иргэд өрөндөө баригдсаар байна. “дархан арьс ширний цогцолбор”-ын 3.9 км урт дулаан, цэвэр усны шугамын ажлыг гүйцэтгэсэн компани өнгөрсөн хугацаанд 4.8 тэрбум төгрөгийн ажил хийгээд байгаа аж. Энэ талаар “бурхант хясаат” ххк-ийн инженер п.батбаатар “одоог хүртэл хийсэн ажлынхаа хөлсийг авч чадаагүй байгаа. Манайх 100 гаруй ажилчинтай. Дархан хотоос сонгогдсон гурван гишүүндээ хүртэл бичиг хүргүүлсэн. Гэтэл одоо болтол шийдэлд хүрч чадаагүй байна” гэсэн юм. Мөн 16 мегабаттын дэд станцыг барьсан “дархан-хэрлэн” ххк-ийн захирал с.ганхуяг “оруулсан санхүүжилтийнхээ 30-40 хувийг авч чадаагүй. Уг нь энэ дэд станц ашиглалтад ороход бараг л бэлэн болчихсон. Одоо хамгаалалт, харилцаа холбооны зохицуулах хэрэгслийн ажил л дутуу байна” гэв. Ноос ноолуур боловсруулах, самнах хэсгийн таван байгууламжийг барихад 3.8 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэсэн “азбаэ” ххк-ийн захирал б.авирмэд “2018 оны наймдугаар сараас төслийн ажил эхэлсэн. Бүтээн байгуулалтын ажил 2019 оны есдүгээр сараас эхэлсэн бөгөөд 10,000 метр квадрат талбай бүхий байгууламжийг барьж гүйцэтгэсэн. Одоо сар бүр 24-25 сая төгрөгийн зээлийн хүү төлж байна.

Одоо болтол мөнгө төгрөгөө авсан ч юмгүй, банк болон банк бусын хүүд баригдсан нөхцөл байдалтай байна” гэж тайлбарлалаа.

нөгөө талаас, ххаахү-ийн сайд з.мэндсайхан “дарханы арьс ширний бүтээн байгуулалт гэдэг төрийн өмчит компани байгуулаад, монгол улсын засгийн газар, ман-ын мөрийн хөтөлбөрт байгаа “дарханы арьс шир боловсруулах үйлдвэр”-ийг байгуулна гэдэг мөрийн хөтөлбөрөө биелүүлж байгаа” гэх тайлбарыг хэвлэл мэдээллийнхэнд өгчээ. Мөн монгол улсын засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга д.амарбаясгалан “ххаахү-ийн сайдтай ярилцаж байгаа байр суурь бол дарханы арьс ширний үйлдвэр, цогцолбор байгуулах зорилготойгоор хөгжлийн банкнаас зээл аваад, үйл ажиллагаагаа тогтвортой явуулж чадаагүй аж ахуйн нэгж нь хөгжлийн банктайгаа өр зээлээ шийдэх асуудлыг өөрсдөд нь үлдээгээд, үйл ажиллагаа явуулахыг нь таслан зогсоох ёстой гэсэн байр суурьтай байгаа” гэсэн тайлбар өгчээ.

товчхондоо бол төр нэхий боловсруулах үйлдвэр барьдгаараа барина, хийдгээ хийнэ. Харин хувийн хэвшлийнхэн төрийн амнаасаа буцсаны өр төлөөс, хариуцлагыг өөрсдөө үүрэх ёстой гэх байр суурийг монгол улсын засгийн газар илэрхийлэв. Гэтэл төрдөө итгэж, байдаг бүхнээ зориулсан хувийн хэвшлийнхэн нааштай хариу сонсоно гэж горьдон хүлээсээр.

Эцсийн эцэст энэ бүхний цаана хөгжлийн банкнаас зээлсэн 18 тэрбум, улсын төсвөөс гаргасан 50 тэрбум төгрөг гэхээс илүү төр нь иргэдийнхээ бизнесийг булааж болно гэсэн муухай жишгийг улам даамжруулж байна. Эд хөрөнгө, цаг хугацаа, итгэл найдвараараа хохирсон иргэд орилоод орилоод төрийн төмөр нүүрийг эргүүлж чадахгүй юм гэж үү. Төр хамгийн муу менежер атлаа хамаг ажилд гар дүрдэг нь муугийн ёс биш монголын ёс болоо юу.

